

БАТЛАВ  
МӨРДӨН БАЙЦААХ АЛБАНЫ ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.ОТГОНЖАРГАЛ

2018 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

ТУСО466

“АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ 45 ХОНОГИЙН АЯН”-НЫ УДИРДАМЖ

2019 оны 03 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Зорилго:** Мөрдөн байцаах албаны алба хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ангид байлгах, авлигын хор хөнөөлийн талаар иргэд, байгууллага, алба хаагчдад мэдээлэл өгөх, Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилхад оршино.

**Бүрэлдэхүүн, хамрах хүрээ, хугацаа:** Мөрдөн байцаах албаны төвийн хэлтсүүд хуваарийн дагуу ээлжлэн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл 45 хоногийн хугацаанд явуулна.  
Үүнд:

Захиргааны удирдлагын хэлтэс 2019.03.25-аас 03.31

Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс 2019.04.01-ээс 04.06

Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс 2019.04.07-оос 04.12

Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс 2019.04.13-аас 04.20

Залилах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс 2019.04.20-оос 04.25

Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс 2019.04.25-аас  
05.01

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2019.05.02-оос 05.08

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

Нэг: Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах.

1.1. Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилах чиглэлээр алба хаагчдад сургалт зохион байгуулах.

Хариуцах нь: Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Х.Мандах.

1.2. Авлигатай тэмцэх газраас зохион явуулж байгаа “Авлигын эсрэг нэг өдөр” сэдэвт сургалтад хуваарь гаргаж алба хаагчдыг оролцуулах.

Хариуцах нь: Захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Золжаргал.

Хоёр: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар алба хаагчдаас баталгаа авах.

2.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар алба хаагчдаас баталгаа авах баталгааны дэвтрийг хэлтсүүдээр аялууулж алба хаагч нэг бүрээс баталгаа авах.

Хариуцах нь: Дүн шинжилгээ, үнэлгээ хяналт шалгалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Алтангадас.

2.2. Төв, орон нутгийн мөрдөн байцаах нэгжүүдэд авлигатай тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол явуулах талаар ажлын чиглэл хүргүүлж биелэлтийг тооцох.

Хариуцах нь: Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч С.Ууганбаяр

Гурав. Бусад ажлын талаар

3.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх санамж, сэрэмжүүлэг, авлигын хор хөнөөлийн талаарх зурагт хуудас, гарын авлага, Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, алба хаагчдад түгээж сурталчилах.

Хариуцах нь: Хэлтсүүд.

3.2. Мөрдөн байцаах албаны [www.mbg.police.gov.mn](http://www.mbg.police.gov.mn) цахим хуудасны мэдээллийг шинэчлэх.

Хариуцах нь: Захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Золжаргал, мэдээлэл холбоо, сүлжээний ахлах инженер, цагдаагийн хошууч Ш.Ганболд.

3.3. Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, тогтоомжийг албаны цахим хуудас, facebook хаягт, үүдний ухаалаг дэлгэцэнд байршуулж нийтэд сурталчилах.

Хариуцах нь: Захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Золжаргал, мэдээлэл холбоо, сүлжээний ахлах инженер, цагдаагийн хошууч Ш.Ганболд.

3.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтын талаар албаны цахим хуудас, facebook хаягт, үүдний ухаалаг дэлгэцэнд байршуулж нийтэд мэдээлэх.

Хариуцах нь: Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч С.Мягмарсүрэн, мэдээлэл холбоо, сүлжээний ахлах инженер, цагдаагийн хошууч Ш.Ганболд.

Дөрөв. Аяны хүрээнд хийсэн ажлыг тайлагнах

Удирдамжийн дагуу хийсэн ажлынхаа тайланг хэлтсүүд 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр тус албаны "Авлигаас урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөл"-д нэгтгэж албаны даргад тайлангана.

УДИРДАМЖ БОЛОВСРУУДСАН;  
ЗАХИРГААНЫ УДИРДАГЫН ХЭЛТСҮЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА А.ГАНСҮХ

